

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/172/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

ӨЛГИЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЭНХЖИН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь 2020 онд зарцуулсан 11,705.3 мянган төгрөгийн шатах тослох материалыг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасныг тайлант онд хөндий зардлаар бүртгэж үр дүнгийн тайлангийн зардлын дүнг өсгөсөн, 617.3 мянган төгрөгийн 266 литр шатах тослох материал зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 зүйлийн 20.1.4 заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасныг зөрчиж сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 1 ажилтанд 990.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож төрд хохирол учруулсан, төсвийн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 3,680.3 мянган төгрөгийн 4 гүйлгээг

хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах” зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх ба үүрэг, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114,630,634.60</u>	<u>174,073,012.48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,822,142.06
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	2,822,142.06
3121	Төгрөг	00.00	2,822,142.06
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,822,142.06
33	АВЛАГА	1,863,810.00	47,225,020.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,353,000.00	1,353,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	45,872,020.00
335	Бусад авлага	510,810.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	250,410.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	260,400.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	112,766,824.60	124,025,850.42
351	Түүхий эд материал	38,052,511.50	13,536,941.50
35130	Эм боох материал	38,052,511.50	13,536,941.50
354	Хангамжийн материал	74,714,313.10	110,488,908.92
35410	Бичиг хэргийн материал	8,478,260.00	9,633,860.00
35420	Аж ахуйн материал	40,705,426.00	85,046,099.22
35430	Сэлбэг хэрэгсэл	3,921,500.00	7,635,000.00
35440	Түлш, шатах тослох материал	15,934,369.00	1,885,000.00
35460	Хүнсний материал	4,939,758.10	5,553,949.70
35470	Бусад хангамжийн материал	735,000.00	735,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>878,812,949.73</u>	<u>958,689,223.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	878,812,949.73	958,689,223.26
392	Биет хөрөнгө	869,824,949.73	949,701,223.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,054,573,295.82	1,046,781,775.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-260,700,972.78	-280,888,327.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,608,000.00	102,880,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,088,500.00	-41,613,166.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,117,234.00	93,111,332.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,875,469.24	-42,446,722.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,224,128.80	34,371,367.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,923,130.82	-13,503,794.81
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,990,141.21	64,275,110.21
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,181,777.26	-13,348,351.16
39217	Ном	82,000.00	82,000.00
393	Биет бус хөрөнгө	8,988,000.00	8,988,000.00
39301	Программ хангамж	330,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-330,000.00	-330,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,988,000.00	8,988,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>993,443,584.33</u>	<u>1,132,762,235.74</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,558,752.00</u>	<u>10,948,540.88</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,558,752.00	10,948,540.88

413	Өглөг	9,558,752.00	10,948,540.88
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,933,331.00	3,311,430.88
4136	Бусад өглөг	3,625,421.00	7,637,110.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,460,022.00	7,637,110.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	165,399.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	983,884,832.33	1,121,813,694.86
51	Засгийн газрын хувь оролцоо	983,884,832.33	1,121,813,694.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	278,814,812.00	278,814,812.00
51101	Өмч: - төрийн	278,814,812.00	278,814,812.00
512	Хуримтлагдсан үр дүн	267,320,970.66	406,249,775.54
51210	Өмнөх үеийн үр дүн	267,320,970.66	268,320,913.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	137,928,862.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	437,749,049.67	436,749,107.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	993,443,584.33	1,132,762,235.74

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	894,070,774.00	893,790,124.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	862,768,314.00	126,163,674.28
120	Нийтлэг татварын бус орлого	468,941,454.00	126,163,674.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	468,941,454.00	126,163,674.28
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	468,941,454.00	126,163,674.28
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	393,826,860.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	393,826,860.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,302,460.00	338,776,850.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	428,849,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,059,400.00	244,295,980.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,829,400.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,230,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	244,295,980.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	33,788,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	33,788,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	6,244,000.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	6,244,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,999,060.00	60,692,770.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,999,060.00	60,692,770.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	433,535,204.78	755,842,512.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,535,204.78	755,842,512.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,251,497.64	689,800,760.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,850,747.86	367,219,741.10
210101	Үндсэн цалин	257,180,066.00	283,765,152.82
210102	Нэмэгдэл	00.00	49,805,671.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	484,000.00	5,030,999.19
210104	Урамшуулал	19,186,681.86	28,197,917.94
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	420,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,267,900.00	41,537,776.72
210201	Тэтгэврийн даатгал	26,560,100.00	28,959,246.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,124,700.00	3,154,017.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,800.00	2,523,214.52
210204	Ажилгүйдлийн даатгал	572,200.00	1,074,602.19
210205	Эрүүл мэндийн даатгал	5,722,100.00	5,826,696.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,573,754.00	31,328,520.79

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	1,513,920.00	2,421,329.79
210302	Түлш, халаалт	16,995,834.00	28,907,191.00
210303	Цэвэр, бохир ус	64,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,663,330.00	58,998,461.00
210401	Бичиг хэрэг	629,800.00	1,456,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,964,780.00	36,439,861.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,007,200.00	1,616,900.00
210404	Ном, хэвлэл	6,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,055,550.00	18,785,100.00
2105	Нормативт зардал	28,671,562.40	134,500,506.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,856,245.50	111,649,561.50
210502	Хоол, хүнс	7,515,916.90	22,850,945.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,299,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	1,696,900.00
210604	Урсгал засвар	200,000.00	1,696,900.00
2107	Томилолт, зочны зардал	280,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	280,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	836,000.00	1,615,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	638,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,100.00	55,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	671,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	87,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,908,203.38	52,763,593.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,649,500.00	1,673,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,258,703.38	51,090,393.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,283,707.14	66,041,752.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	65,697,033.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	65,697,033.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,283,707.14	344,719.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,283,707.14	344,719.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>460,535,569.22</u>	<u>137,947,612.05</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	18,749.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	18,749.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-18,749.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>460,535,569.22</u>	<u>137,928,862.53</u>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	425,129,320.00	721,754,430.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	393,826,860.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	393,826,860.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	393,826,860.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,302,460.00	721,754,430.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	428,849,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,059,400.00	244,295,980.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,829,400.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,230,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	244,295,980.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,244,000.00	33,788,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	33,788,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	6,244,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,999,060.00	14,820,750.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,999,060.00	14,820,750.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	425,129,320.00	718,932,287.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,129,320.00	718,932,287.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,845,612.86	652,890,535.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,855,647.86	364,146,745.08
210101	Үндсэн цалин	249,098,236.43	282,122,508.58
210102	Нэмэгдэл	00.00	47,260,817.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,807,997.60	4,524,981.43
210104	Урамшуулал	18,909,491.71	27,718,516.07
210105	Гэрээт ажлын хөлс	5,039,922.12	2,519,922.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,763,000.00	47,232,672.86
210201	Тэтгэврийн даатгал	24,318,900.00	34,563,839.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,861,000.00	3,176,593.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,800.00	2,541,275.02
210204	Ажилгүйдлийн даатгал	572,200.00	1,079,117.32
210205	Эрүүл мэндийн даатгал	5,722,100.00	5,871,847.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,003,784.00	31,958,980.79
210301	Гэрэл, цахилгаан	1,513,920.00	2,421,329.79
210302	Түлш, халаалт	19,489,864.00	29,537,651.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,295,540.00	67,222,213.00
210401	Бичиг хэрэг	1,501,700.00	3,276,400.00

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	15,050,640.00	24,297,933.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,107,200.00	1,616,900.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	896,000.00	1,085,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,640,000.00	36,945,980.00
2105	Нормативт зардал	35,525,641.00	102,330,644.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,960,700.00	69,515,547.00
210502	Хоол, хүнс	8,139,941.00	23,405,097.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,425,000.00	9,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,374,500.00	35,732,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,800,000.00	28,489,800.00
210602	Тавилга	00.00	1,668,480.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	75,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,499,500.00	4,774,400.00
2107	Томилолт, зочны зардал	280,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	280,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,379,000.00	1,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	638,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,100.00	55,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	671,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	72,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,368,500.00	2,526,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,368,500.00	2,526,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,283,707.14	66,041,752.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	65,697,033.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	65,697,033.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,283,707.14	344,719.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,283,707.14	344,719.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	2,822,142.06
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,822,142.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,822,142.06

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	269,826,812.00	343,439,188.91	-297,790,879.91	315,475,121.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	20,728.85	20,728.85
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,826,812.00	343,439,188.91	-297,770,151.06	315,495,849.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	8,988,000.00	00.00	33,370,869.44	42,358,869.44
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	278,814,812.00	437,749,049.67	267,320,970.66	983,884,832.33
2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	278,814,812.00	437,749,049.67	267,320,970.66	983,884,832.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	999,942.35	999,942.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	278,814,812.00	437,749,049.67	268,320,913.01	984,884,774.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-999,942.35	00.00	-999,942.35
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,928,862.53	137,928,862.53
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	278,814,812.00	436,749,107.32	406,249,775.54	1,121,813,694.86

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	478,500,900.00	474,291,588.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,500,900.00	474,291,588.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,500,900.00	474,291,588.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,887,800.00	316,885,928.08
210101	Үндсэн цалин	280,183,300.00	282,122,508.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	4,524,981.43
210104	Урамшуулал	28,376,500.00	27,718,516.07
210105	Гэрээт ажлын хөлс	2,520,000.00	2,519,922.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,779,800.00	41,225,339.86
210201	Тэтгэврийн даатгал	30,104,300.00	28,556,506.91
210202	Тэтгэмжийн даатгал	3,168,900.00	3,176,593.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,535,300.00	2,541,275.02
210204	Ажилгүйдлийн даатгал	633,500.00	1,079,117.32
210205	Эрүүл мэндийн даатгал	6,337,800.00	5,871,847.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,288,100.00	31,958,980.79
210301	Гэрэл, цахилгаан	3,750,000.00	2,421,329.79
210302	Түлш, халаалт	28,218,100.00	29,537,651.00
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,837,000.00	32,826,213.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,511,400.00
210402	Тээвэр, шатахуун	22,107,000.00	21,738,433.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,530,000.00	1,616,900.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00	1,085,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,700,000.00	6,874,480.00
2105	Нормативт зардал	40,830,700.00	40,828,127.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,730,700.00	28,730,700.00
210502	Хоол, хүнс	8,100,000.00	8,097,427.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,800,000.00	6,784,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,484,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,150,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,420,700.00	1,116,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	110,600.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	55,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	465,000.00
210807	Газрын төлбөр	75,000.00	72,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3506800.00	2526600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,506,800.00	2,526,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	478,500,900.00	477,113,730.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	428,849,600.00	428,849,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	428,849,600.00	428,849,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,788,100.00	33,443,380.79
132001	Орон нутгийн төсвөөс	33,788,100.00	33,443,380.79
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,863,200.00	14,820,750.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,863,200.00	14,820,750.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,822,142.06
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	244,295,980.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	244,295,980.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,598,947.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,260,817.00
210102	Нэмэгдэл	47,260,817.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,007,333.00
210201	Тэтгэврийн даатгал	6,007,333.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,396,000.00
210401	Бичиг хэрэг	1,765,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,559,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,071,500.00
2105	Нормативт зардал	61,502,517.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,784,847.00
210502	Хоол, хүнс	15,307,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,948,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,989,800.00
210602	Тавилга	1,668,480.00
210604	Урсгал засвар	3,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	484,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	278,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	206,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65697033.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,697,033.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	65,697,033.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	244295980.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	244,295,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	244,295,980.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь Иргэдэд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 3,468.3 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 755,842.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 7,558.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,046.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймаг Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,186.6 мянган төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,822.1	2,822.1
Авлага	1,863.8	47,225.0	45,361.2
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	112,766.8	124,025.9	11,259.1
Үндсэн хөрөнгө	878,813.0	958,689.2	79,876.2
Нийт хөрөнгө	993,443.6	1,132,762.2	139,318.6
Өр төлбөр	9,558.8	10,948.5	1,389.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	983,884.8	1,121,813.7	137,928.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	993,443.6	1,132,762.2	139,318.6

Авлага дансны үлдэгдэл 47,225.0 төгрөг болж 45,361.2 мянган төгрөгөөр өсөхөд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 124,025.9 мянган төгрөг болж 11,259.1 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн бараа материалыг орлогод авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 958,689.2 мянган төгрөг болж 79,876.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар болон төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 30,789.1 мянган төгрөг, хандиваар 100,196.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталж устгасан 24,078.6 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,948.5 мянган төгрөг болж 1,389.8 мянган төгрөгөөр өссөн эмийн өглөг өссөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,121,813.7 мянган төгрөг болж 137,928.9 мянган төгрөгөөр өссөн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 280.6 мянган төгрөгөөр буюу 0.03 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 322,307.3 мянган төгрөгөөр буюу 74.3 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 583,500.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 583,500.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10,500.0 мянган төгрөгөөр бууруулж 478,500.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 478,500.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 428,849.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 33,788.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15,863.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 428,849.6 мянга, орон нутгийн төсвөөс 33,788.1 мянга Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,820.7 мянга, нийт 477,458.4 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд 474,291.6 мянган төгрөгийг зарцуулж 344.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 474,291.6 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь зардлыг 344.7 мянган төгрөгөөр хэмнэж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,042.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,822.1 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 244,296.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 112, хугацаа хоцроож 37 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 45,872.0 мянган төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,302.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 990.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16,002.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 3,308.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.2 Төлбөрийн акт

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг зөрчиж сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 1 ажилтанд 990.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож төрд хохирол учруулсанд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

1. Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь 2020 онд зарцуулсан 11,705.3 мянган төгрөгийн шатах тослох материалыг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасныг тайлант онд хөндий зардлаар бүртгэж үр дүнгийн тайлангийн зардлын дүнг өсгөсөн, 617.3 мянган төгрөгийн 266 литр шатах тослох материал зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлээгүй алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

2. Төсвийн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 3680.3 мянган төгрөгийн 4 гүйлгээг хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах” зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Харилцагч талын гарын үсгээр баталгаажаагүй тооцооны үлдэгдлийн баталгааг үндэслэж 3,308.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ хийсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын Эрүүл мэндийн төв	4	20,302.0			1	990.6	2	16,002.9	1	3,308.5
	НИЙТ	4	20,302.0			1	990.6	2	16,002.9	1	3,308.5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР /Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр